



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 8/01

Жаргалтхаан

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралт, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6, 7 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 3,10,11 дүгээр хавсралт, “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 1, 4, 6 дугаар хавсралт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 18 дугаар хуралдааны 02 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын үндсэн цалинг хавсралтанд заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн шинэчлэн тогтоосугай.

2.Албан хаагчдын үндсэн цалинг хавсралтад зааснаар тооцон, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэл, хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийн нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч Э.Загдхүүд зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дугаартай тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



С.МӨНХДЭЛГЭР

Data (D:) /A4 tushaal/

Засаг даргын Тамгын газрын даргын  
2025 оны 01 сарын 03 өдрийн 001 тоот  
тушаалын... дүгээр хавсралт

Үндсэн цалин болон цалингийн нэмэгдлүүдийг шинэчлэн тогтоосон жагсаалт

| №  | Албан хаагчдын нэрс | Албан тушаал                                            | Зэрэглэл | Үндсэн цалин | Нэмэгдлүүдийн хувь хэмжээ             |                       |                      |                                |
|----|---------------------|---------------------------------------------------------|----------|--------------|---------------------------------------|-----------------------|----------------------|--------------------------------|
|    |                     |                                                         |          |              | Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл | Зэрэг дэвийн нэмэгдэл | Ур чадварын нэмэгдэл | Орон нутагт ажилласны нэмэгдэл |
| 1  | Г.Түмэнжаргал       | Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн             | ТЗ-7     | 1,539,000    | 12%                                   | 22%                   |                      | 60%                            |
| 2  | З.Жанчив            | Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8     | 1,399,000    | 7%                                    | 18%                   |                      | 60%                            |
| 3  | Г.Мөнхсайхан        | Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн                      | ТЗ-9     | 1,283,000    | 14%                                   | 18%                   |                      | 60%                            |
| 4  | П.Батдулам          | Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн                      | ТЗ-9     | 1,283,000    | 5%                                    | 18%                   |                      | 60%                            |
| 5  | Н.Энхзул            | Архив, бичиг хэргийн эрхлэгч                            | ТҮМ-3    | 1,283,000    | 6%                                    |                       | 25%                  | 40%                            |
| 6  | Э.Загдхүү           | Нягтлан бодогч                                          | ТҮМ-7    | 1,559,000    |                                       |                       | 25%                  | 40%                            |
| 7  | Г.Жавзанжамъян      | Нярав                                                   | ТҮ-4     | 1,105,000    | 5%                                    |                       | 25%                  | 40%                            |
| 8  | Х.Түвшинбаяр        | Жолооч                                                  | ТҮ-3     | 1,052,000    | 7%                                    |                       | 25%                  | 40%                            |
| 9  | Ц.Энхцэцэг          | Үйлчлэгч                                                | ТҮ-1     | 954,000      | 10%                                   |                       | 25%                  | 40%                            |
| 10 | Б.Ариунсүх          | Жижүүр, сахиул                                          | ТҮ-1     | 954,000      | 2%                                    |                       | 25%                  | 40%                            |
| 11 | Н.Баттулга          | Жижүүр, сахиул                                          | ТҮ-1     | 954,000      | 5%                                    |                       | 25%                  | 40%                            |
| 12 | Б.Эрдэнэжаргал      | Жижүүр, сахиул                                          | ТҮ-1     | 954,000      | 1%                                    |                       | 25%                  | 40%                            |